

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГҮҮДИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛД

Д.Оюунбадам

АСУУДАЛ

Улсын төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд баримтлах зарчмууд хэрэгжихгүй байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуульд “Төсвийг төлөвлөн, баталж, хэрэгжүүлэхдээ төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах; санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх; ил тод байдлыг ханган, хариуцлагатай байх” гэсэн зарчмуудыг баримтлах тухай заасан байдаг. Гэсэн хэдий ч эдгээр зарчмын хэрэгжилт сул байна. Үүний нэг жишээ нь төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл төлөвлөгдсөн хугацаандаа хэрэгжихгүй удаашрах, улмаар төсөвт өртөг нь жилээс жилд нэмэгдэх явдал газар авсаар байгаа юм. Энэ байдал Засгийн газраас УИХ-д өргөн бариад буй Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслөөс ч мөн харагдаж байна¹. Тухайлбал, 2010-2014 онд буюу 7-10 жилийн өмнө эхэлсэн, нийт 250 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 26

барилга, байгууламжид (Хавсралт 1-ийг харна уу) 2022 оны төсвөөр 38.5 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөжээ. Барилга байгууламжийн төрлөөр авч үзвэл зургаан спорт цогцолбор, дөрвөн театр, Засаг даргын Тамгын газрын хоёр барилга, хичээлийн хоёр байр болон бусад байгууламж байна. Эдгээрийн 12 нь Улаанбаатар хотод байршилтай байна.

Дуусгаагүй удсан барилгуудын төсөвт өртөг 286 саяас 11 тэрбум төгрөгөөр өссөн нь 2022 оны төсвийн төслөөс харагдаж байна. Зарим барилгын төсөвт өртгийн өсөлтийг График 1-д харуулав.

Ийнхүү төслийн хэрэгжилт удааширч, төсөвт өртөг өссөнөөр төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг буурч байна.

¹ Засгийн газар (2021 оны 10 дугаар сар). Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төсөл, танилцуулга. (<http://forum.parliament.mn/projects/11171>)



Д.ОЮУНБАДАМ (PhD), Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер

ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн хүрээнд төсвийн ил тод, хариуцлагатай байдлын асуудлаар ажилладаг. Тэрээр улс, орон нутгийн төсвийн нээлттэй байдал, төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийн чиглэлээрх төслүүдийг удирдаж байв. Мөн эдийн засаг, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар олон улсын сэтгүүлүүдэд хэд хэдэн нийтлэл хэвлүүлсэн ([researchgate.net/profile/Oyunbadam_Davaakhuu](https://www.researchgate.net/profile/Oyunbadam-Davaakhuu)). Д.Оюунбадам нь бакалаврын зэргээ Хүмүүнлэгийн ухааны сургуульд, магистрын зэргээ Япон Улсын *Waseda*-гийн их сургуульд, докторын зэргээ Австрали Улсын *Charles Sturt*-ийн их сургуульд тус тус хамгаалсан.

График 1. Дуусаагүй зарим барилгын үнийн өсөлт (тэрбум төгрөгөөр)



Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төслүүдийн эхний санхүүжилтийг хуулийн дагуу төлөвлөхгүй байна.

Төсвийн тухай хуулийн 29.3.5 дахь “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” заалт хэрэгжихгүй байна. Шинэ төслүүдийн эхний санхүүжилтийг хэт бага төлөвлөж, эхний жилд нь барилгын шав тавихаас хэтрэхгүй ажил цөөнгүй байна. 2022 оны төсөвт туссан, хэрэгжилт удааширсан барилгуудын заримд эхний санхүүжилтийг маш бага төлөвлөж байжээ (График 2-ыг харна уу). Тухайлбал, БЗД-ийн спорт цогцолборыг эхний жилд нь

нийт төсөвт өртгийн дөнгөж 0.4 хувь (10 сая төгрөг)-иар санхүүжүүлэхээр тусгасан. Засгийн газраас боловсруулан танилцуулж буй төсвийн хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтад санхүүжилтийг зөвхөн мөнгөн дүнгээр илэрхийлсэн мэдээлэл харуулахаас төлөвлөж буй шинэ төслийн нийт төсөвт өртгийн хэдэн хувийг эхний жилд санхүүжүүлж байгааг харуулдаггүй. Ийм байдлаар Засгийн газраас боловсруулан танилцуулж буй хөрөнгө оруулалтын жагсаалтад Төсвийн тухай хуулийн холбогдох заалтад нийцсэн төлөвлөлт явж байгаа эсэхийг шууд харуулахгүй байгаа нь учир дутагдалтай юм.

График 2. Он дамжсан зарим барилгын эхний санхүүжилт төлөвлөгдсөн байдал




Эх сурвалж: Монгол Улсын нэгдсэн төсвийн төслийн баримт бичгүүд

График 2-оос харахад Архангай аймгийн хөгжимт драмын театрын барилгын нийт төсвийн (5.1 тэрбум) 3.9 хувь буюу 200 сая төгрөг, Баянзүрх дүүргийн 13-р хороонд баригдах Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спорт танхимын барилгын нийт төсөвт өртгийн 15 хувийг эхний жилд нь санхүүжүүлэхээр тусгажээ. Эдгээр барилга нь анх 2012 оны төсөвт тусгагджээ. Цаашилбал, Сонгинохайрхан дүүрэг дэх Найрамдал зуслангийн Усан спорт цогцолборын барилга анх нийт төсөвт өртөг 5 тэрбум төгрөг байсан ба үүнээс 900 сая төгрөгийг нь эхний жилд санхүүжүүлэхээр баталж байжээ. Эдгээр нь бүгд хөрөнгө оруулалтын төслийн эхний

санхүүжилтийг маш багаар төлөвлөж, Төсвийн тухай хуулийг зөрчсөний бодит жишээ юм.

Дээрх зөрчил 2022 онд шинээр эхлэх төслүүдийн төлөвлөлтөд ч мөн давтагдаж байна. Тухайлбал, 2022-2024 онд буюу гурван жилийн хугацаанд хэрэгжих 76 төслийн эхний санхүүжилт хуульд заасан хэмжээнд хүрэхгүй (нийт төсөвт өртгийн 25 ба түүнээс бага хувь) байна. Төсвийн тухай хуулийн дагуу эдгээр төслийн төсөвт өртгийн 33-аас багагүй хувийг 2022 онд санхүүжүүлэх ёстой юм. Шинээр эхлэх нийт 80 төслөөс 49-д нь 20-иос бага хувиар эхний санхүүжилтийг олгохоор, түүний дотор 14 төслийн төсөвт өртгийн арваас бага хувийг санхүүжүүлэхээр тусгажээ (График 3).

График 3. Нийт төсөвт өртгийн бага хувиар эхний санхүүжилт авах төслүүдийн тоо



Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төсөл, танилцуулга

Тухайн төслийн нийт төсөвт өртгийн 25, түүнээс бага хувийг эхний жилд нь санхүүжүүлэхээр тусгасан 80 төслөөс хамгийн олон буюу 14 нь Улаанбаатарт, 13 нь Говь-Алтай аймагт, 9 нь Хөвсгөл аймагт байршилтай байна (Зураг 1). Улаанбаатарт төлөвлөгдсөн барилгаас жишээ дурдвал, Сүхбаатар дүүрэгт баригдах Нийслэлийн хоёрдугаар төрөх болох “Хүрээ амаржих” газрын

барилгын нийт төсөвт өртөг 18 тэрбум төгрөг байгаагийн 11 хувь буюу хоёр тэрбум, Баянгол дүүрэгт баригдах 200 ортой цэцэрлэгийн барилгын нийт төсөвт өртөг 4.4 тэрбум төгрөг байгаагийн 11 хувь буюу 500 сая, Баянзүрх дүүрэгт баригдах 200 ортой цэцэрлэгийн барилгын нийт төсөвт өртөг 4.1 тэрбум төгрөг байгаагийн 12 хувь буюу 500 сая төгрөгийг тус тус тусгажээ.

Зураг 1. Монгол Улсын 2022 оны төсвийн санхүүжилтээр шинээр эхлэх төслүүд
(эхний санхүүжилт нь төсөвт өртгийн 25 ба түүнээс доош хувиар тусгагдсан төсөл)



Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төсөл, танилцуулга

Орон нутагт 2022 онд шинээр эхлэх ч хөрөнгө оруулалтын эхний санхүүжилтийн хэмжээ хуулийн шаардлагыг хангахгүй байгаа төслүүдээс дурдвал, Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны сургуулийн дотуур байрны 2.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий барилга гурван жилийн хугацаанд баригдах боловч нийт төсвийн таван хувь буюу 150 сая төгрөг улсын төсөвт тусгажээ (Хавсралт 3-ыг харна уу). Мөн аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төвийн барилга, Сэлэнгэ аймаг дахь “Алтанбулаг” чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөлийн ажилд тус бүр төсөвт өртгийн дөнгөж зургаан хувьтай тэнцэхүйц санхүүжилтийг тусгажээ. Тэрчлэн Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сум дахь дотуур байрны

барилгын төсөвт өртгийн найман хувь, Хэнтий аймгийн Жаргалтхаан, Өмнөдэлгэр сум дахь 2023 онд дуусгахаар төлөвлөгдсөн Улаанбаатар-Чингис хот чиглэлийн авто замаас Өмнөдэлгэр сум хүртэлх хатуу хучилттай 52.5 км авто замын нийт төсөвт өртгийн (53.9 тэрбум төгрөг) есөн хувийг л санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Цаашилбал, Дорнод аймгийн Хэрлэн сум дахь аймгийн төвийн 1,800 айлын орон сууцны хорооллын цахилгаан хангамж, инженерийн шугам сүлжээг 2024 онд дуусгахаар төлөвлөхдөө нийт төсөвт өртгийн (9.8 тэрбум төгрөг) 10 хувийг төлөвлөжээ. Барилгын суурийг ч тавьж хүрэхгүй ийм бага хэмжээний санхүүжилт нь он дамжсан, дуусдаггүй барилгын тоог нэмэгдүүлэх эрсдэл дагуулж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн мэдээллийг хуулийн дагуу бэлтгэж, хууль тогтоогчдыг иж бүрэн мэдээллээр хангах хэрэгтэй байна.

Дээр дурдсан шиг хууль зөрчсөн төслүүдийг Засгийн газрын төсөвт тусгахгүй байхын тулд төсвийн төлөвлөлтийн баримт бичгийн агуулгын иж бүрдэлд тавигдах шаардлагыг боловсронгуй

болгох хэрэгтэй байна. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тавигдах шаардлагын тухайд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг жилийн төсвийн төсөлд тусгахдаа улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан төсөл, арга хэмжээний нийт өртөг, эхлэх болон дуусах хугацаа, төсвийн жилд зарцуулах хэмжээгээр тусгах, шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах”-аар заасан. Ийнхүү Засгийн газраас боловсруулсан төсвийн хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтад зөвхөн тухайн жилийн санхүүжилтийг мөнгөн дүнгээр илэрхийлсэн мэдээлэл л тусгахаас шинэ төслийн нийт төсөвт өртгийн хэдэн хувийг эхний жилд төлөвлөж буйгаа харуулдаггүй. Энэ нь тухайн төслийн төлөвлөлт хуульд нийцсэн эсэхийг хууль тогтоогчид шууд харах боломжгүй болгодог.

Мөн Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т “Улсын Их Хурал төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар батлахдаа төслийн нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүнг тусгах”-аар заажээ. Өнөөдрийн байдлаар УИХ-д өргөн барьж буй Монгол Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад шинээр эхлүүлэх болон өмнөх оноос шилжих төслүүдийг хамтад нь багтаан төсөл, арга хэмжээний хуулийн дугаар, нэр, хүчин чадал, байршил, эхлэх, дуусах хугацаа, төсөвт өртөг, санхүүжих дүнг тусгаж байна. Энэхүү маягтад шинэ төслүүд нь Төсвийн тухай хуулийн 29.3.5 заалтыг хангаж буй эсэхийг харуулсан буюу шинэ төслүүдийн эхний санхүүжилтийн нийт төсөвт өртөгт эзлэх

хувь хэмжээний мэдээлэл багтаагүй байна. Мөн шилжих төслүүдийн хувьд зөвхөн өргөн барьж буй төсөлд туссан төсөвт өртгийг л тусгаснаас тухайн төслийн анх батлагдсан төсөвт өртгийн мэдээлэл багтаагүй байна. Гэтэл зарим шилжих төслийн анх батлагдсан төсөвт өртөг 286 саяас 11 тэрбумаар нэмэгдсэн байгаа талаар дээр дурдсан. Ийнхүү хөрөнгө оруулалтын шинэ болон шилжих төслүүдийн мэдээллийн иж бүрдэл хангалтгүй байгаа нь УИХ-ын гишүүд бүрэн мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах боломжийг хязгаарлаж байна. Иймд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтын одоогийн маягтыг шинэчилж боловсруулах нь зүйтэй.

Түүнчлэн батлагдсан төсөл, арга хэмжээнд дахин давтагдахгүй код олгохгүй байна. Иймд тухайн жилийн төсөвт батлагдсан төсөл, арга хэмжээнд дахин давтагдахгүй код оноож, тэрхүү код нь тухайн төслийг хэрэгжиж дуусах хүртэл ашиглагддаг болгох хэрэгтэй. Учир нь төсөвт туссан хөрөнгө оруулалтад одоо оноож буй хуулийн дугаар нь дараа оны төсөвт тусгахдаа өөрчлөгдөж байгаа нь олон нийт уг төслийн төлөвлөлт, хэрэгжилтийн бүхий л үе шатанд хяналт тавихад бэрхшээл учруулж байна.

Мөн Засгийн газраас төсвийн тодотголын төсөл өргөн барихдаа төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төлөвлөлтийн дэлгэрэнгүй мэдээллийг УИХ-ын гишүүдэд өгөхгүй байна. Тухайлбал, тодотголд хэрэгжүүлэхээр тусгасан хөрөнгө оруулалтын төслүүдийн хувьд худалдан авах ажиллагаа хийгдсэн эсэх, тодотголоор нэмэгдсэн болон хасагдсан төслүүдийн жагсаалт, тухайн онд санхүүжих дүн өөрчлөгдсөн эсэх зэрэг мэдээллийг төсөл тус бүрээр тусгадаггүй. Энэ бүхнийг Төсвийн тухай хуульд зохицуулалт болгон оруулах шаардлагатай.

Төсвийн төлөвлөлтийн зарим мэдээллийн иж бүрэн байдал хангагдахгүй байна.

Засгийн газар төсвийн талаарх шийдвэрүүдийн төсөл, гарсан шийдвэрээ олон нийтэд таниулах, тэдний оролцоог хангах нь нэн чухал юм. Монгол

Улсын төсвийн зарим баримт бичгийн мэдээллийн иж бүрдэл сул байгаа нь Олон улсын төсвийн түншлэл байгууллагаас зохион байгуулдаг

“Төсвийн нээлттэй байдал” судалгааны дүнгээс харагддаг². Тухайлбал, агуулгын иж бүрэн байдлаар авбал зохих 100 онооноос Засгийн газрын төсвийн төсөл 60 хувийг, УИХ-аар батлагдсан төсөв 30 хувийг авчээ (Хүснэгт 1). Энэ нь төсвийн төлөвлөлтийн шатанд олон нийтэд хүрэх мэдээллийн агуулгыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Хүснэгт 1. Монгол Улсын төсвийн зарим баримт бичгийн агуулгын иж бүрэн байдал (авбал зохих 100 онооноос)

Төсвийн баримт бичиг	Баримт бичгийн агуулгын оноо
Засгийн газрын төсвийн төсөл	59
Батлагдсан төсөв	33

Эх сурвалж: “Төсвийн нээлттэй байдал-2019” судалгааны дүнгээс

Олон улсын сайн туршлагатай харьцуулахад Монгол Улс төсвийн төслийн баримт бичгийн мэдээллийн иж бүрэн байдлаа сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал, манай улсын төсвийн төсөлд дараах мэдээллүүд багтдаггүй. Үүнд:

- Орлого, зарлагын тооцооллыг төсвийн жилээс цааш хамгийн багадаа хоёр жилээр, төсвийн дэлгэрэнгүй ангиллаар боловсруулсан байдлаар;
- Төсвийн жилийн эцсийн байдлаарх болон төсвийн жилийн өмнөх жилийн өрийн хүү, өрийн дуусах хугацаа, нийт өрийн бүтцийн мэдээлэл;
- Төсвийн тооцооллыг хийхдээ суурилсан хүүгийн түвшний мэдээлэл;
- Макро эдийн засгийн янз бүрийн төсөөлөл нь төсөвт үзүүлэх нөлөөлөл (өөрөөр хэлбэл, мэдрэмжийн шинжилгээ)-ийн мэдээлэл;
- Төсвийн жилийн өмнөх жилийн зарлагыг зориулалтаар ангилсан байдлаар;

- Засгийн газрын бодлогуудын санхүүгийн нөлөө хүн амын янз бүрийн бүлэгт ямар байхыг харуулсан зардлын хувилбарууд (хүйсээр, насаар, орлогын түвшнээр эсхүл бүс нутгаар гэх мэтээр);
- Төсвийн жилийн байдлаарх Засгийн газарт буй санхүүгийн хөрөнгийн жагсаалт, үнийн дүнгийн мэдээлэл (Засгийн газрын санхүүгийн хөрөнгөд бэлэн мөнгө, үнэт цаас болон хувьцаа зэрэг багтдаг);
- Төсвийн жилийн байдлаарх Засгийн газарт буй санхүүгийн бус хөрөнгийг төрлөөр нь ангилсан мэдээлэл (Засгийн газрын санхүүгийн бус хөрөнгөд газар, барилга, машин тоног төхөөрөмж зэрэг багтдаг);
- Засгийн газрын цаашдын өр төлбөр болон түүний санхүүгийн тогтвортой байдлыг урт хугацаанд үнэлсэн тооцоолол (Энэхүү үнэлгээний гол үзүүлэлтүүдэд хамгийн багадаа 10 жилээр хийсэн тооцоолол, тухайн тооцооллыг хийхдээ авч үзсэн макро эдийн засгийн болон хүн амын төсөөллүүд, санхүүгийн үр дагавар ба тооцооллоор гарсан гол эрсдэлүүдийн талаарх дүгнэлт, мэдээлэл багтдаг).

Тэрчлэн төсвийн нээлттэй байдлыг хангахад шаардлагатай УИХ-аас батлагдсан төсвийн баримт бичгийн мэдээллийн иж бүрдэл хангагдахгүй байна. Өөрөөр хэлбэл, олон улсын сайн туршлагатай харьцуулахад манай улс батлагдсан төсөвтөө доорх мэдээллийг нийтэлдэггүй. Үүнд:

- Зарлагыг эдийн засгийн, зориулалтаар болон хөтөлбөрөөр ангилсан мэдээлэл;
- Орлогыг эх үүсвэрээр ангилсан байдлаар (татварын болон татварын бус гэх мэт);
- Төсвийн жилийн эцсийн байдлаарх нийт өрийн дүн болон төсвийн жилд хийгдэх өрийн хүүгийн төлбөрийн дүн.

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлд төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөн, гүйцэтгэлийг

² <https://www.internationalbudget.org/open-budget-survey/country-results/2019/mongolia>

хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнахаар заасан ба төсвийг дараах байдлаар ангилахаар тусгажээ. Үүнд, төсвийн шатлалаар, төсвийн захирагчаар, эдийн засгийн ангиллаар, хөтөлбөрөөр, арга хэмжээгээр болон санхүүжүүлэх эх үүсвэрээр. УИХ-д өргөн барьсан төсвийн төслийн баримт бичгийн иж бүрдэлд Төсвийн тооцооллын хавсралтууд багтдаг бөгөөд нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлтийг дэлгэрэнгүй ангиллаар

боловсруулж оруулсан байдаг. Үүнд, зарлагыг эдийн засгийн ангиллаар, зориулалтаар, төсвийн захирагчаар болон орлогыг эх үүсвэрээр нь ангилсан мэдээлэл багтдаг. Гэсэн хэдий ч УИХ-аар батлагдсан төсөвт орлого, зарлагыг зөвхөн төсвийн захирагчийн ангиллаар нийтэлдэг байна. Иймд Төсвийн тухай хуулийн 33.2-т УИХ төсөв батлахдаа тусган, батлах зүйлд бусад ангиллыг нэмж оруулах хэрэгтэй байна.

ТӨСВИЙН ХАРИУЦЛАГАА САЙЖРУУЛАХАД ЗАЙЛШГҮЙ ХИЙХ АЛХМУУД

Төсвийн төлөвлөлтийг сайжруулах, мэдээллийн иж бүрэн, нээлттэй байдлыг дээшлүүлэх үүднээс төсвийн төлөвлөлтийн баримт бичгийн агуулгад тавигдах шаардлагыг боловсронгуй болгох хэрэгтэй. Улмаар дараах алхмуудыг авч хэрэгжүүлэх тал дээр УИХ, Засгийн газар болон Сангийн яам анхааран ажиллахыг судлаачийн зүгээс зөвлөж байна. Үүнд:

1. *Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн мэдээллийн иж бүрэн байдлыг одоогийн түвшинээс дээшлүүлэх.* Үүнд:

- Монгол Улсын ирэх оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт дахь “Улсын төсвийн хөрөнгөөр ирэх онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт” маягыг боловсронгуй болгох. Үүний тулд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг шинээр эхлэх болон шилжих төслүүдээр тус тусад нь хавсралтаар боловсруулан баталдаг болох нь зүйтэй. Шинээр эхлэх төслүүдийн маягтад төсвийн хөрөнгө оруулалтын одоо ашиглаж буй маягт дахь мэдээллээс гадна “тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүнг нийт төсөвт өртөгт эзлэх хувиар” гэсэн мэдээллийг; шилжих төслүүдийн маягтад төсвийн хөрөнгө оруулалтын одоо ашиглаж буй маягт дахь мэдээллээс гадна “анх батлагдсан төсөвт өртөг” гэсэн мэдээллийг тус тус нэмэх;

- Төсвийн тодотгол хийгдэх тохиолдолд УИХ-д өргөн баригдах төсөлд туссан хөрөнгө оруулалтын төслүүдийн хувьд худалдан авах ажиллагаа хийгдсэн эсэх, тодотголоор нэмэгдсэн болон хасагдсан төслүүдийн жагсаалт, тухайн онд санхүүжих дүн өөрчлөгдсөн эсэх мэдээллийг маягтад мөн тусгадаг байхаар тусгайлсан маягт боловсруулах;

- Дээрх нэмэлт, өөрчлөлтүүдийг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, 33 дугаар зүйлийн 33.2-т тусгах.

2. *Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бүртгэлийг боловсронгуй болгох.* Тухайн жилийн төсөвт батлагдсан төсөл, арга хэмжээнд дахин давтагдахгүй код оноож, тэрхүү код нь тухайн төслийг дуусах хүртэл ашиглагддаг байх зохицуулалтыг Төсвийн тухай хуульд оруулах, Төсвийн хөрөнгөөр ирэх онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын маягтад нэмэх.

3. *Монгол Улсын төсвийн төслийн баримт бичгийн мэдээллийн иж бүрэн байдлыг сайжруулах.* Дараах мэдээллийг Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т нэмж тусгах. Үүнд:

- Зарлагын тооцооллыг төсвийн жилээс цааш хамгийн багадаа хоёр жилээр, төсвийн аль нэг ангиллаар (эдийн засгийн, төсвийн захирагчаар, зориулалтаар, хөтөлбөрөөр);

- Орлогын тооцооллыг төсвийн жилээс цааш хамгийн багадаа хоёр жилээр, ангиллаар (татварын болон татварын бус гэх зэрэг);
 - Төсвийн жилийн эцсийн байдлаарх болон төсвийн жилийн өмнөх жилийн өрийн хүү, өрийн дуусах хугацаа, нийт өрийн бүтцийн мэдээлэл;
 - Төсвийн тооцооллыг хийхдээ суурилсан хүүгийн түвшний мэдээлэл;
 - Макро эдийн засгийн янз бүрийн төсөөлөл нь төсөвт үзүүлэх нөлөөлөл(өөрөөр хэлбэл, мэдрэмжийн шинжилгээ)-ийн мэдээлэл;
 - Төсвийн жилийн өмнөх жилийн зарлагыг зориулалтаар ангилсан байдлаар;
 - Засгийн Газрын бодлогуудын санхүүгийн нөлөө хүн амын янз бүрийн бүлэгт ямар байхыг харуулсан зардлын хувилбарууд (хүйсээр, насаар, орлогын түвшнээр эсхүл бүс нутгаар гэх мэтээр);
 - Төсвийн жилийн байдлаарх Засгийн газарт буй санхүүгийн хөрөнгийн мэдээлэл (хөрөнгийн жагсаалт, үнийн дүн);
 - Төсвийн жилийн байдлаарх Засгийн газарт буй санхүүгийн бус хөрөнгийг төрлөөр нь ангилсан мэдээлэл;
 - Засгийн газрын цаашдын өр төлбөр болон түүний санхүүгийн тогтвортой байдлыг урт хугацаанд үнэлсэн тооцоолол.
4. *Монгол Улсын Их Хурлаас баталсан төсвийн баримт бичгийн мэдээллийн иж бүрэн байдлыг сайжруулах.* Дараах мэдээллийг Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т нэмж тусгах. Үүнд:
- Зарлагыг эдийн засгийн ангиллаар, зориулалтаар болон хөтөлбөрөөр ангилсан байдлаар;
 - Орлогыг эх үүсвэрээр ангилсан байдлаар (татварын болон татварын бус гэх мэт);
 - Төсвийн жилийн эцсийн байдлаарх нийт өрийн дүн болон төсвийн жилд хийгдэх өрийн хүүгийн төлбөрийн дүн.

---- 000 ----

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд туссан он дамжсан барилгууд (2010-2014 онд эхэлсэн)

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг (сая төг.)	2022 онд санхүүжих дүн (сая төг.)
			Эхлэх	Дуусах		
1	III.1.1.1	Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал (УБ, БЗД)	2010	2022	11,014.8	2,735.5
2	III.1.1.2	Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал (УБ, СБД)	2010	2023	9,936.8	2,864.9
3	III.1.1.3	Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал (УБ, Налайх дүүрэг)	2010	2022	13,497.7	2,883.5
4	III.1.1.5	Нийслэлийн спорт цогцолбор, 1000 суудал (УБ, ХУД)	2010	2023	7,280.2	2,573.3
5	III.1.1.24	Спорт цогцолбор, 2200 суудал (Дархан-Уул, Дархан сум)	2010	2022	27,116.0	1,878.5
6	V.1.1.1	Аймгийн ЗДТГ-ын газрын барилга (Дорнод, Чойбалсан сум)	2011	2022	9,130.4	3,142.1
7	XII.1.15	Барилга байгууламжийн хийц бүтээцийн газар хөдлөл, сорил шинжилгээний төв лабораторийн барилга (УБ, СХД)	2011	2022	4,183.8	861.2
8	XIV.1.1	"Төв халх" дуулалт жүжгийн театр (Дундговь, Сайнцагаан сум)	2011	2023	10,543.7	1,000.0
9	XIV.1.52	Хан-Хэнтий чуулгын барилга (Хэнтий, Хэрлэн сум)	2011	2022	11,459.4	1,727.0
10	XIV.1.53	Хөгжимт жүжгийн театрын барилга, 800 суудал (Завхан, Улиастай сум)	2011	2022	13,492.0	1,633.5
11	XIII.1.1.128	ХААИС-ийн хичээлийн 2-р байрын барилга (УБ, ХУД)	2012	2023	6,996.6	361.7
12	XIII.1.1.229	Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спорт танхимын барилга (УБ, БЗД, 13-р хороо)	2012	2023	4,286.0	286.0
13	XIV.1.3	Аймгийн хөгжимт драмын театрын барилга (Архангай, Эрдэнэбулган сум)	2012	2022	13,982.2	2,475.9
14	XIV.1.23	Соёлын төвийн барилга (Өмнөговь, Ноён сум)	2012	2022	895.0	105.4
15	XIV.1.51	Үндэсний номын сангийн барилга (УБ, СБД)	2012	2022	19,900.0	2,081.8
16	III.1.1.34	Хүүхэд, залуучуудын соёл, үйлчилгээний цогцолбор, усан бассейн байгуулах (Архангай, Эрдэнэбулган сум)	2013	2022	2,446.7	152.0

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг (сая төг.)	2022 онд санхүүжих дүн (сая төг.)
			Эхлэх	Дуусах		
17	V.1.1.13	Сумын ЗДТГ-ын барилга (Завхан, Тэс сум)	2013	2022	1,200.0	75.0
18	XII.1.23	Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц (УБ, СХД)	2013	2022	5,000.0	500.0
19	XIII.2.1.1	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байр (Орхон)	2013	2022	3,473.9	100.0
20	XIII.2.1.4	ХААИС-ийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр (Орхон, Баян-Өндөр сум)	2013	2022	5,208.9	1,914.1
21	XIX.1.15	Сумын төвийн шинэчлэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эмнэлэг, 100 ор (Дорноговь, Замын-Үүд сум)	2013	2022	8,058.0	1,651.9
22	XI.1.1.4	Усан спорт цогцолбор (УБ, СХД, Найрамдал зуслан)	2014	2023	16,056.2	3,456.2
23	XII.1.55	Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г, д Ø800-ийн гол шугамыг Ø1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөв, барилга угсралтын ажил (1 дүгээр хорооллын урд талаас баруун 4 замын уулзвар хүртэл, павильон 19-өөс 3) 11 холбоос хүртэл 3.4 км (УБ, СХД)	2014	2024	24,949.0	2,000.0
24	XIII.1.1.39	Сургуулийн барилга, 220 суудал (Хөвсгөл, Цагаан-Үүр сум)	2014	2023	2,023.5	102.9
25	XIII.1.1.165	Цэцэрлэгийн барилга, 150 ор (Орхон, Баян-Өндөр сум)	2014	2022	1,651.4	178.5
26	XVIII.1.6	Дулааны цахилгаан станц 4-өөс У-18 хүртэлх (Москва хорооллын урд тал хүртэл) 4.2 км, 800-ийн голчтой дулааны шугамын барилга угсралтын ажил (УБ)	2014	2023	16,987.3	1,800.0
НИЙТ					250,769.5	38,540.9

Хавсралт 2. Монгол Улсын 2022 оны төсвийн төсөл: Хөрөнгө оруулалтын зарим төслийн төсөвт өртөг нэмэгдсэн байдал (сая төгрөг)

№	Хуулийн дугаар	2022 ОНЫ ТӨСӨВТ ТУССАН БАЙДАЛ			АНХ БАТЛАГДСАН БАЙДАЛ					Төсөвт өртгийн зөрүү
		Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	Он/Хуулийн дугаар	Эхлэх, дуусах	Төсөвт өртөг	Батлагдсан оны эхний санхүүжилт	Эхний санхүүжилтийн хэмжээ (нийт төсөвт өртөгт эзлэх хувь)	
1	III.1.1.1	Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал (УБ, БЗД)	2010-2022	11,014.8	2010/ XVII.1.63	2010-2011	2,561.3	10	0.4%	8,453.5
2	XIII.1.1.128	ХААИС-ийн хичээлийн 2-р байрын барилга (УБ, ХҮД)	2012-2023	6,996.6	2012/ XXI.1.1.223	2012	900.0	900	100.0%	6,096.6
3	XIII.1.1.229	Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спорт танхимын барилга (УБ, БЗД, 13-р хороо)	2012-2023	4,286.0	2012/ XXI.3.1.6	2012-2014	4,000.0	600	15.0%	286.0
4	XIV.1.3	Аймгийн хөгжимт драмын театрын барилга (Архангай, Эрдэнэбулган сум)	2012-2022	13,982.2	2012/ XXI.2.1.61	2012-2013	5,100.0	200	3.9%	8,882.2
5	XIV.1.23	Соёлын төвийн барилга (Өмнөговь, Ноён сум)	2012-2022	895.0	2012/ XXI.2.1.66	2012	600.0	600	100.0%	295.0
6	III.1.1.34	Хүүхэд, залуучуудын соёл, үйлчилгээний цогцолбор, усан бассейний байгуулах (Архангай, Эрдэнэбулган сум)	2013-2022	2,446.7	2013/ XXIII.2.1.8	2013	1,500.0	1500	100.0%	946.7
7	XIII.2.1.4	ХААИС-ийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр (Орхон, Баян-Өндөр сум)	2013-2022	5,208.9	2013/ XXVI.2.1.7	2013	2,162.0	1081	50.0%	3,046.9
8	XI.1.1.4	Усан спорт цогцолбор (УБ, СХД, Найрамдал зуслан)	2014-2023	16,056.2	2013/ XXIII.2.1.1	2013	5,000.0	900	18.0%	11,056.2
9	XIII.1.1.39	Сургуулийн барилга, 220 суудал (Хөвсгөл, Цагаан-Үүр сум)	2014-2023	2,023.5	2014/ XVI.1.1.163	2014	1,400.0	1400	100.0%	623.5
10	XIII.1.1.165	Цэцэрлэгийн барилга, 150 ор (Орхон, Баян-Өндөр сум)	2014-2022	1,651.4	2014/ XVI.1.1.174	2014	1,250.0	650	52.0%	401.4
				НИЙТ			24,473.3	7,841		40,088.0

Хавсралт 3. Монгол Улсын 2022 оны төсвийн санхүүжилтээр шинээр эхлэх төслүүд: Эхний санхүүжилт нь төсөвт өртгийн 10 ба түүнээс доош хувиар тусгагдсан

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	Эхний санхүүжилтийн хэмжээ (нийт төсөвт өртөгт эзлэх хувь)
1 XIII.1.1.315	Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 320 ортой (Говь-Алтай, Есөнбулаг сум, Харзат баг, 6-р цэцэрлэг)	2024	4,319.4	200.0	5%
2 XIII.1.1.298	Сургуулийн дотуур байрны барилга (Говь-Алтай, Дэлгэр сум, Гуулин тосгон)	2024	2,853.0	150.0	5%
3 XIX.1.62	Эрүүл мэндийн төвийн барилга (Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон)	2024	2,480.0	150.0	6%
4 IV.1.1.1	"Алтанбулаг" чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөл (Сэлэнгэ, Алтанбулаг сум)	2024	15,634.1	1,000.0	6%
5 XII.1.127	Сумын ундны усан хангамжийн дэд бүтэц (Говь-Алтай, Халиун сум)	2024	2,565.0	200.0	8%
6 XII.1.122	Сумын төвийн инженерийн шугам сүлжээний холболт, уурын зуухны барилга (Говь-Алтай, Бигэр сум)	2024	2,493.8	200.0	8%
7 XII.1.123	Сумын төвийн инженерийн шугам сүлжээний холболт, уурын зуухны барилга (Говь-Алтай, Халиун сум)	2024	2,449.5	200.0	8%
8 XII.1.148	Цэвэр усны шугам сүлжээний шинэчлэл, 1.5 км (Говь-Алтай, Есөнбулаг сум)	2024	2,436.0	200.0	8%
9 XIII.1.1.256	Дотуур байрны барилга, 100 ортой (Хөвсгөл, Шинэ-Идэр сум)	2024	2,880.1	240.0	8%
10 XIV.1.66	Соёлын төвийн барилга, 250 суудалтай (Говь-Алтай, Халиун сум)	2024	2,292.1	200.0	9%
11 XV.1.1.80	Улаанбаатар-Чингис хот чиглэлийн авто замаас Өмнөдэлгэр сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 52.5 км (Хэнтий, Жаргалтхаан, Өмнөдэлгэр сум)	2023	53,910.0	5,000.0	9%
12 XII.1.84	Аймгийн төвийн 1800 айлын орон сууцны хорооллын цахилгаан хангамж, инженерийн шугам сүлжээ (Дорнод, Хэрлэн сум)	2024	9,800.0	960.0	10%
13 XIII.1.2.19	Цэцэрлэгүүдийн шүдний кабинет, тохижилт (УБ, ЧД)	2023	2,000.0	200.0	10%
14 XIII.1.3.18	Ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын тоног төхөөрөмж (Дархан-уул)	2024	2,000.0	200.0	10%
НИЙТ			108,113.0	9,100.0	